



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/125

Халбан

**Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх
яаралтай дархлаажуулалтын ажил зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 9.4 дэх хэсэг, 9.5 дахь хэсэг, 9.6 дахь хэсэг, 9.7 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн А/509 дугаар захирамж, Хөвсгөл аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 02-ний өдрийн А/39 дугаар тушаал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад бүх хонин сүрэг, бойжиж буй хурга, ишгийг бүрэн хамруулах арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 05-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 25-ний өдрүүдэд хамруулж дуусгахыг "Баялаг үйл-Ундрах" мал эмнэлгийн эзэн, малын эмч М.Баатаржав, "Таг дүүрэн сүрэг" мал эмнэлгийн эзэн, малын эмч Н.Доржжүгдэр, бусад малын эмч мэргэжилтнүүд, багийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Яаралтай дархлаажуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр ханган шатахууны дэмжлэг үзүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч (Н.Алтанхуяг), Нягтлан бодогч (М.Отгон-Өлзий) нарт үүрэг болгосугай.

4. Малчдыг тогтоосон хугацаанд нэг цэгт малаа бэлэн байлгах, хүн хүчний нөөцийг бүрдүүлэх, зарлан мэдээлэл хүргэх зэрэг шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг бүх багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР



Цэцэрлэг сумын Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 03-ны өдрийн А/13 тоот
захирамжийн 2 дугаар хавсралт

**БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЯАРАЛТАЙ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

2024.10.03

1. Н.Анхбаяр – Сумын Засаг дарга
2. Н.Алтанхуяг – МЭТ-ийн дарга, мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч.
3. Д.Энхцэцэг - Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
4. Бүх багийн Засаг дарга нар

.....оОо.....

Цэцэрлэг сумын Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 03-ны өдрийн А/ 125
тоот захирамжийн 1-р хавсралт

**БММӨ-ний яаралтай дархлаажуулалтанд хамрагдах малын тоо /толгой/
2024.10.03.**

№	Багийн нэр	МЭҮН-ийн нэр.	Бүх том хонь /толгой	Бүгд хурга./ толгой	Бүгд ишиг. /толгой	Бүгд малын тоо /толгой/	Олгох вакцин /тун/	Шингэлэгч /литр/
1	Дэлгэрхаан	Таг дүүрэн сүрэг	25397	8354	7195	40946	56495	
2	Генчинжугна		20706	6323	3832	30861	41016	
3	Уранхайрхан		33098	11502	5929	50529	67960	
4	Жаргалант		21673	7787	4278	33738	45803	
	Дүн-1		100874	33966	21234	156074	156074	156 литр
5	Зуунмод	Баялаг үйл-Ундрах	26506	9521	8837	44864	44864	
6	Халбан		6178	2140	1684	10002	10002	
7	Бүрхээр		5580	1883	1135	8598	8598	
	Дүн-2		38264	13544	11656	63464	63464	63.5 литр
	Сумын дүн		139138	47510	32890	219538	219538	219.5 литр

Боловсруулсан: Цэцэрлэг сумын МЭТ-ийн дарга
Мал эмнэлгийн хяналтын Улсын байцаагч
Н.Алтанхуяг